

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2018 ОНЫ ХУРАЛДААНЫ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Шийдвэрлэлт
1.	Салбар зөвлөлийн 2018 оны төлөвлөгөө батлах тухай	2018.02.26	Салбар зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд гишүүдийн саналыг тусган, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн шийдвэр, Авлигатай тэмцэх газрын зөвлөмж, Засгийн газрын зорилтот жилийн хүрээнд Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн 2018 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 үндсэн чиглэл 13 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган Салбар зөвлөлийн даргаар батлуулав.
2.	Салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай		Салбар зөвлөлийн 2018 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд гишүүдийн гаргасан саналын дагуу өөрчлөлт оруулан Салбар зөвлөлийн даргаар батлуулав.
3.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.04.03	Хайрхандулаан сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн Долгорсүрэн, Хайрхандулаан сумын ЗДТГ-ын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн А.Батсайхан нарыг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгэж, нэгдсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан Долгорсүрэн, Батсайхан нарыг Салбар зөвлөлд уламжилан тухайн өрсөлдсөн албан тушаалд томилуулав.
4.	Дэвшүүлэн томилох шалгалтын дүнгийн тухай	2018.04.13	Томилох эрх бүхий этгээд дээрх зөвлөмжид хавсаргасан хүснэгтийн дагуу тухай удирдах албан тушаалд тус хэлтсийн байцаагч Банзрагчийн Гантуяа, Сосорбурамын Эрхэмбаяр нарын танилцуулга, холбогдох бичиг баримтыг ирүүлсэн. Б.Гантуяа сорилын шалгалтад 20.5, ярилцлагын шалгалтад 14, С.Эрхэмбаяр сорилын шалгалтад 19, ярилцлагын шалгалтад 11 оноо тус тус авлаа. Шалгалтын нэгдсэн үнэлгээгээр Б.Гантуяа 60.81, С.Эрхэмбаяр 43.46 оноо авч, аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн даргын төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Б.Гантуяа тэнцсэн тул төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгүүлж, томилуулахаар нэр дэвшүүлэв.
5.	Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнуулахаар ирүүлсэн албан хаагчдыг материалыг хэлэлцэх тухай	2018.05.22	Нийт 9 иргэн Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнуулахаар материал ирүүлснээс Салбар зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Даваанямын Нэмэхбаяр, аймгийн ИТХ-ын ажлын албаны ахлах мэргэжилтэн Буухүүгийн Балжинням, Стандарт хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулалтын албаны дарга

			Дүгэрсүрэнгийн Байгальмаа, Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Бат-Очирын Загдзэсэм, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн Юндэнгийн Нямсүрэн, Зүүнбаян-Улаан сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Цэрэгийн Одонжаргал нарыг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнуулахаар тодорхойлов. 3 иргэний материалыг шаардлага хангахгүй гэж үзлээ.
6.	Төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөөцөөс нөхөх тухай	2018.06.12	Төрийн жинхэнэ албан тушаалын ажлын байрны сул орон тоог нөөцөөс нөхөх зарын дагуу 1 иргэн материалаа ирүүлсэн. Уг иргэний материалыг хэлэлцээд Хархорин сумын ЗДТГ-ын багийн зохион байгуулагчийн сул орон тоонд холбогдох байгууллагад захиалгынх нь дагуу төрийн жинхэнэ албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэв.
7.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.06.14	Төгрөг сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 3 иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгүүлэх, нэгдсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан Н.Оюунгэрэлийг тухайн ажлын байранд нэр дэвшүүлж томилуулах саналыг Салбар зөвлөлд уламжилан Н.Оюунгэрэлийг нэр дэвшүүлж томилуулав.
8.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.06.25	БОАЖГ-ын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 1 иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгүүлэх, нэгдсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан Т.Ариунболдыг тухайн ажлын байранд нэр дэвшүүлж томилуулах саналыг Салбар зөвлөлд уламжилсан.
9.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.09.18	Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгүүлэх, нэгдсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан Б.Сайнжаргалыг тухайн ажлын байранд нэр дэвшүүлж томилуулах саналыг Салбар зөвлөлд уламжилсан.
10.	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	2018.10.01	Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 2018 оны 12 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад оролцогчийг бүртгэх, шалгалтын бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг байгуулж, 2018 оны 9 дүгээр сарын 24, 25-ны өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд явуулж, ажлын байрны сул орон тоо зарлагдсан 19 ажлын байранд нийт 80 иргэнийг цахимаар бүртгэсэн. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай" 2013 оны 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журам, зааврын дагуу 09 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, зарлагдсан 19 ажлын байрнаас 7 ажлын байранд

			тэнцсэн 16 иргэдийн дэс болон туслах түшмэлийн төрийн жинхэнэ албаны төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх, хамгийн өндөр оноо авсан иргэдийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулах саналыг Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын төв комисст уламжилсан.
11.	Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.10.03	Богд сумын Соёлын төвийн эрхлэгчийн ажлын байрны сонгон шалгаруулалтад Н.Ганболд тэнцэж нийт 71.0 оноо, Хархорин сумын Соёлын төвийн эрхлэгчийн ажлын байрны сонгон шалгаруулалтад Ц.Оюунчимэг нийт 74.7, О.Отгончимэг нийт 72.1 оноо авч тус тус тэнцсэн. Шалгалтын нэгдсэн үнэлгээ, нэрсийн жагсаалтыг гаргаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд уламжилсан.
12.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох /Эрүүл мэндийн газрын дарга, Биеийн тамир, спортын газрын дарга, Стандарт хэмжил зүйн газрын дарга, Насан туршийн боловсролын төвийн дарга, Хархорин сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Тарагт, Арвайхээр сумдын Засаг даргын Тамгын газрын дарга/ ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.10.23	Сорилын шалгалтаар Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд 1, Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалд 1, Стандарт, хэмжил зүйн газрын даргын албан тушаалд 1, Насан туршийн боловсролын төвийн даргын албан тушаалд 2, Хархорин сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд 2, Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд 11, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд 1 нийт 19 иргэн сорилын шалгалтад тэнцсэн. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 19 иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгүүлэх, өндөр үнэлгээ авсан 7 иргэнийг тухайн өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэх саналыг Салбар зөвлөлд уламжилъя.
13.	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай	2018.12.24	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад тэнцсэн 2 иргэнийг төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны нөөцөд бүртгүүлэх, нэгдсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан Ш.Бямбацэрэнг тухайн ажлын байранд нэр дэвшүүлж томилуулах саналыг Салбар зөвлөлд уламжилан Н.Оюунгэрэлийг нэр дэвшүүлж томилуулав.

14.	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай	2018.12.24	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын бүртгэлийг 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдөр 09.00-18.00 цагийн хооронд аймгийн Засаг даргын Тамгын газрын 315, 316, 317 тоот өрөөнд явуулж, ажлын байрны сул орон тоо зарлагдсан 27 ажлын байрнаас 24 ажлын байранд 96 иргэнийг цахимаар бүртгэсэн.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтыг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар”-ын дагуу зохион байгуулж, зарлагдсан 27 ажлын байрны 24 ажлын байранд тэнцсэн 35 иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх, нөөцөд бүртгүүлэх иргэдээс хамгийн өндөр оноо авсан 16 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулах саналыг Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын төв комисст уламжиллаа.
15.	Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнуулахаар ирүүлсэн албан хаагчдыг материалыг хэлэлцэх тухай	2018.12.28	Нийт 2 иргэн Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдэг"-ээр шагнуулахаар материал ирүүлснээс Салбар зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Т.Гончигдорж, аймгийн НДХ-ийн хяналтын улсын байцаагч Э.Бадамсүрэн нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар тодорхойлов.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ